



СОЁМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

МЭДЭЭ

№138 /352/

2022.08.08

Цаг үе, үйл явдал

ХУРАНДАА АДЬЯАГИЙН ДАВААСАМБУУ НЭРЭМЖИТ ТАСАГТАЙ БОЛЛОО



Цэргийн төв эмнэлгийн Эрчимт эмчилгээ, мэдээгүйжүүлэг, хагалгааны нэгдсэн төвийн Эрчимт эмчилгээний тасгийг Мэдээгүйжүүлэг эрчимт эмчилгээний зөвлөх зэргийн эмч, клиникийн профессор, хурандаа Адьяагийн Даваасамбуу агсны нэрэмжит болголоо. Тэрээр Цэргийн төв эмнэлгийн сэхээн амьдруулах нэгжийг үүсгэн байгуулж, хөгжүүлж бэхжүүлэх, эмч, эмнэлгийн ажилтнуудыг сургаж бэлтгэх, цэргийн алба хаагчид болон ард иргэдийн

эрүүл мэндийг сахин хамгаалахад жинтэй хувь нэмрээ оруулсан нэгэн юм. Түүний үйл хэргийг мөнхлөх зорилгоор ийнхүү ажил, амьдралынхаа гарааг эхлүүлсэн тус тасгийг нэрэмжит болгох ёслолын ажиллагаа өнөөдөр зохион байгуулагдлаа.

Нэрэмжит болгох ёслолын арга хэмжээнд А.Даваасамбуу агсны хань ижил, үр хүүхэд, ах дүү төрөл төрөгсөд, Цэргийн төв эмнэлгийн удирдлага, хамт

олон, хамтран зүтгэж байсан ахмад буурлуудын төлөөлөл оролцож, алдар гавьяа, бахархам түүхийг нь дурслаа.

Хурандаа Адьяагийн Даваасамбуугаар овоглосон Эрчимт эмчилгээний тасаг нь Батлан хамгаалахын сайдын 1977 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн тушаалаар Армийн төв эмнэлэгт Сэхээн-амьдруулах тасаг нэртэйгээр үүсэн байгуулагдаж байжээ. Түүхэн хөгжлийнхөө явцад цаг үеийн хэрэгцээ шаардлагаар бүтцийн хувьд хэдэнтэй

өөрчлөгдсөн ч 2022 онд Эрчимт эмчилгээ, мэдээгүйжүүлэг, хагалгааны нэгдсэн төв болон үйл ажиллагааны цараа нь улам нэмэгдэн хүний алтан амийг дэнслэх хариуцлагатай үүргээ тасралтгүйгээр гүйцэтгэсээр байна. Өнөөдрийн байдлаар тус тасаг нь эмчилгээний 12 ор болон хөнгөвчлөх эмчилгээний 4 ортой, 30 гаруй эмч, сувилагч, эмнэлгийн ажилтнуудтай үйл ажиллагаагаа явуулж байна.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 21	🌧️ 8


ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 31	🌧️ 22

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3.190.00	3.200.0
EUR 🇪🇺	3.260.0	3.285.0
CNY 🇨🇳	472.00	475.00
RUB 🇷🇺	49.20	50.20
JPY 🇯🇵	23.50	24.00
KRW 🇰🇷	2.41	2.43

ЗУРХАЙ



2022.08.08 /ДАВАА ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 11

ЗУНЫ АДАГ УЛААГЧИН ХОНЬ САРЫН НАЙМАН ЦАГААН МЭНГЭТЭЙ ХАРАГЧИН МОГОЙ ӨДӨР

Үс засуулбал:

Эрхтэн хурц болно

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

05.38-20.18

Барилдлага:

Рашаан Шүтэн

Шүтэн барилдлага:

Төрөн түгэхүй

Суудал: Шороо

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛГИЙН ХӨДӨЛГӨӨНТ ЯВУУЛЫН АМБУЛАТОРИ БАРУУН АЙМГИЙН ЗҮГ ХӨЛГИЙН ЖОЛОО ЗАЛЛАА



Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Батлан хамгаалах яам, Эрүүл мэндийн яам хоёрын хамтын ажиллагааны хүрээнд Цэргийн төв эмнэлгийн хөдөлгөөнт явуулын амбулатори урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн үйлчилгээг баруун аймгийн иргэдэд үзүүлэхээр замдаа гарлаа.

ЭМЯ-аас 2022 оныг "Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах" жил болгон зарласан бөгөөд өнгөрсөн тавдугаар сарын 1-ний өдөр орон даяар хүн амыг урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд

үнэгүй хамруулах үйл ажиллагаа эхлүүлсэн.

Цэргийн төв эмнэлгийн хөдөлгөөнт явуулын амбулатори дээрх арга хэмжээнд эхэлсэн цагаас нь хойш үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд энэ хугацаанд 1200 гаруй иргэдийг урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулжээ. Эдгээр 1200 хүний 75-80 хувь нь эрүүл, үлдсэн 20-25 хувь нь даралт ихсэх, ходоод гэдэс, элэг цөсний өвчлөл, мэс засал, арьс, бэлгийн замын өмчлөлүүд эхний байруудад орсон байна. Дээрх өвчлөл оношлогдсон

иргэдийг цаашид хэрхэн эмчлэх зөвлөмжүүдийг өгч дараагийн шатны эмчилгээнд харуулжээ.

Харин өнөөдөр Баруун аймгийн зүг хүлгийн жолоо залж буй хөдөлгөөнт явуулын амбулатори нь 22 хүний бүрэлдэхүүнтэйгээр хөдөллөө.

Тэднийг Цэргийн төв эмнэлгийн дарга, ерөнхий эмч, хурандаа Б.Энх-Од, штабын дарга дэд хурандаа Б.Ганболд нар гарган өгч хүн ардыг эрүүлийг хамгаалах их үйлсэн нь амжилт хүсэж аян замдаа саадгүй сайн явхийг хүслээ.

Тус бүлэг энэ удаад Зэвсэгт хүчний 256 дугаар ангиас урьдчилан

сэргийлэх, эрт ажлаа эхлэх бөгөөд нийт 2 сарын хугацаанд Өвөрхангай, Баянхонгор, Говь-алтай, Увс, Завхан зэрэг баруун 5 аймагт байрлах Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчид, тэний гэр бүлийн гишүүд, цэргийн тэтгэвэр чөлөөндөө гарсан ахмад дайчдаас гадна нутгийн иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлнэ.

Цэргийн төв эмнэлгийн хөдөлгөөнт явуулын амбулаторийн нэг бүлэг 22 эмч сувилагч ажилтан алба хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр 21 хоногийн хугацаатай үүрэг гүйцэтгэх бөгөөд хаана байгаа газар нь дараагийн бүрэлдэхүүн очин ээлж хүлээлцэх зарчмаар 2 сарын турш 5000 иргэдэд хүрч ажиллана.

Энэ хугацаанд Цэргийн төв эмнэлгийн эмч, сувилагч, ажилтан алба хаагчид маань хүн амын дунд зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоог оновчтой, хүнд ээлтэй, нэгдсэн зохион байгуулалттай хэрэгжүүлнэ. Түүнчлэн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хүн амыг хамруулснаар хүний амь нас, амьдралын чанарт ноцтой хохирол учруулах, цаашид хөгжлийн бэрхшээлд хүргэж болзошгүй өвчнийг эрт үед нь илрүүлж, улмаар үр дүнтэй эмчилж, ирээдүйд учирч болзошгүй хүндрэл, нас баралт, санхүүгийн дарамтаас сэргийлэх чухал ач холбогдолтой юм.

/Лргэлжлэл нь II нүүрт/

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 589,610,561

Эдгэрсэн

Нийт: 561,096,670

Нас барсан

Нийт: 6,436,778

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛГИЙН ХӨДӨЛГӨӨНТ ЯВУУЛЫН АМБУЛАТОРИ БАРУУН АЙМГИЙН ЗҮГ ХӨЛГИЙН ЖОЛОО ЗАЛЛАА

/Түрүүч нь I нүүрт/ Ташрамд, Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг нь эмгэг шинж тэмдэггүй, эрүүл гэж өөрсдийгөө тооцдог хүн амд урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ, оношилгоо хийснээр эрсдэлт хүчин зүйл болон өвчин, эмгэгийг илрүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээ юм. Тодруулбал, 18 наснаас дээш бүх иргэдэд эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, шинжилгээг явуулын амбулаторийн үйлчилгээг үзүүлэх юм.

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн нийт хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах шийдвэр гарсантай холбогдуулан Эрүүл

мэндийн сайдын 2022 оны А/139 дүгээр тушаал, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 06 дугаар тогтоолын дагуу урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоог зохион байгуулна.

Эдгээр тогтоол, тушаалын дагуу иргэн бүрийг жилд 1 удаа урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулахаар зохицуулсан бөгөөд насанд хүрэгчид насны бүлгээс хамаарч үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамрагдана. Тухайлбал, "зүрх судасны өвчин, чихрийн шижин, сүрьеэ, сэтгэцийн эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээ", "лабораторийн шинжилгээгээр: биохими, цус болон шээсний ерөнхий шинжилгээ, өлөн үеийн глюкоз, өтгөнд далд цус илрүүлэх, ПАП сорил, гепатит В, С, тэмбүү, ХДХВ илрүүлэх хурдавчилсан сорил",

"багажийн шинжилгээгээр: зүрхний цахилгаан бичлэг, улаан хоолой, ходоодны дуран, цээжний рентген шинжилгээ, хөх, хэвлийн, бамбайн хэт авиан шинжилгээ хийлгэж, эмчийн үзлэг, дүгнэлт, зөвлөгөөг авахаар товлосон.

Харин 0-17 насны хүүхэд мөн насны бүлгээс хамаарч үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамрагдана. Тухайлбал, "Хүүхдийн сэтгэхүйн хөгжил болон сэтгэц, зан үйлийн эмгэг, сүрьеэгийн эрсдэлийн үнэлгээ", "эмнэл зүйн үзлэгээр: биеийн хэмжилт, өсөлт, хөгжлийн үнэлгээ, нүдний хараа шалгах, амны хөндийн эрүүл мэнд"-ийн үзлэг хийж, дүгнэлт, зөвлөгөө авах боломжтой.

Иргэд дараах 6 насны бүлгийн багцын дагуу урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамрагдаж байгаа юм.



Үүнд:

1. 0-5 насны багц
2. 6-17 насны багц
3. 18-30 насны багц
4. 31-45 насны багц
5. 46-60 насны багц
6. 61-ээс дээш насны багц

0-17 насны хүүхэд өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн сум, тосгоны эрүүл мэндийн төвд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багцад хамрагдах бөгөөд насанд хүрсэн даатгуулагчийн хувьд өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн урилга, зохицуулалттайгаар эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээ байгуулсан лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагаас сонгох байдлаар урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн багцад хамрагдана.

Цахим шууданд

ЯПОН УЛСЫН ИНЖЕНЕРИЙН ЦЭРГҮҮД МОНГОЛ ҮНДЭСНИЙ СОЁЛ, УЛАМЖЛАЛААР "АМЬСГАЛАВ"



Монгол Улсын Зэвсэгт хүчин, Япон Улсын Өөрийгөө хамгаалах хүчний хамтарсан 12 дахь удаагийн "Зам-2022" хамтарсан дадлага, сургалт амжилттай үргэлжилж байна. Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийг түшиглэн явагдаж байгаа энэ удаагийн сургуулиар Монгол Улсын Зэвсэгт хүчний инженерийн мэргэжлийн офицер, ахлагч нарыг зам барих аргад сурган дадлагажуулах, багшлах бүрэлдэхүүнийг бэлтгэх, мэдлэг, ур чадварыг нь нэмэгдүүлэх, туршлага солилцохоор онол, дадлагын хичээлийг 20 гаруй хоногийн хугацаатай явуулж байна.

Сургалт, дадлагын нэгдсэн төлөвлөгөөний дагуу хоёр улсын цэргийн алба хаагчдад өөр өөрийн орны түүх, соёл уламжлалыг сурталчлах, спорт, соёл хүмүүжлийн ажлууд явагдаж байгаа бөгөөд 8 дугаар сарын 6-ны өдөр "Бэсрэг наадам" болон Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулгын уран бүтээлчдийн тоглолт зохион байгуулагдсан.

Монгол соёл уламжлалаа сурталчилсан "Бэсрэг наадам"-аар Япон Улсын инженерийн цэргүүд үндэсний дээлээр гоёж, бөх барилдаж, сур, шагай харваж, үндэсний хоол, айраг цагаан идээ зооглон нэгэн өдрийг үр бүтээлтэй өнгөрүүлсэн юм.

Тэд "Монголчууд агуу түүх, уламжлалтай ард түмэн. Үндэсний уламжлал нь дахин давтагдашгүй сонирхолтой өв соёл юм. Монгол цэргүүдтэй

хамтран ажиллаж байгаадаа бид баяртай байна. Монгол цэргүүдийн суралцах чадвар өндөр, оновчтой шийдвэр гаргахдаа тун сайн" гэж тодорхойлж байв.

Энэхүү арга хэмжээ нь хоёр улсын цэргийн алба хаагчдын нөхөрсөг уур амьсгалыг бүрдүүлж, гар нийлэмжтэй ажиллагааг сайжруулах, тэдний нөхөрлөлийг бататгахад чухал ач холбогдолтой юм.



АЛБАН ТУШААЛЫН 8 АЙЛЫН ОРОН СУУЦНЫ БАРИЛГЫГ АШИГЛАЛТАД ХҮЛЭЭЛГЭН ӨГӨВ



Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн Увс аймгийн Зүүнговь суманд байрлах 328 дугаар тусгай салбарт Зэвсэгт тушаалын орон сууцаар хүчний Хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар шинээр баригдсан албан тушаалын 8 айлын орон сууцны барилгыг ашиглалтад хүлээлгэн өгөв.

Тус байранд офицер, ахлагч нарын 4 гэр бүл нийт 12 цэргийн алба хаагч албан тушаалын орон сууцаар хангагдлаа. Байрны нээлтийн арга хэмжээнд Батлан хамгаалах яамны барилга хүлээж авах ажлын хэсгийн дарга, БХЯ-ны Стратегийн

бодлого төлөвлөлтийн газрын Батлан хамгаалах бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга хурандаа Д.Дашзэвэг, гишүүд болох Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын Материал, техникийн хэлтсийн дарга хурандаа Г.Хашчулуун, БХЯ-ны Барилга захиалагчийн албаны дарга ахлах дэслэгч Э.Мөнхнаран болон Зүүнговь сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Б.Баяртогтох, Засаг даргын тамгын газрын дарга Б.Цээлэйнамсан нар оролцлоо.

Энэ үеэр Увс аймгийн Засаг даргын тамгын газрын дарга Б.Цээлэйнамсан алслагдсан сум орон нутагт хэрэгтэй нүдээ олсон ажил болсон талаар хэлж, цаашид салбарын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхээ илэрхийллээ.

Ташрамд тус салбарт шинээр ашиглалтад орсон орон сууцны сумын төвлөрсөн дулаанд холбох ажлыг хийж энэ сард багтаан дуусгахаар ажиллаж байна.

